

## БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ВАН СЯОЛУНГИЙН ХЭЛСЭН ҮГ

Өнөөдрийн эрдэм шинжилгээний бага хурал тун амжилттай болж өнгөрлөө. Юуны өмнө Ноён Жао Цижэн профессор бид бүхэнд Хятад улсын цаашдын өөрчлөлт хөгжлийн бодлого чиглэлийг тайлбарлан таниулав. Түүний үндсэн дээр Хятад Монголын талаас үг хэлсэн хүмүүс дэлгэрүүлэн хэлэлцлээ. Өнөөдрийн хэлэлцүүлгийн явцад бид бүхэн тус эрдэм шинжилгээний бага хурлын үндсэн сэдэв болох «Хятадын шинэчлэлийн бүх талын гүнзгийрэл ба Хятад Монголын харилцааны хөгжлийн шинэ боломж» гэсэн асуудлаар илүү гүнзгий ойлгоцтой болов.

Бид бүхэн Хятадын Коммунист Намын 18 дахь удаагийн 3 дугаар Бүгд Хурлаас өөрчлөлт шинэчлэлийн талаар гаргасан чухал шийдвэрийн тухайд эхний дүгнэлтийг гаргаж болох юм. Өөрөөр хэлбэл Хятад улсын ирээдүйн тав болон арван жилийн хөгжлийн тал дээр цөөн хэдэн үг хэлэх боломжтой болов. Юуны өмнө Хятадын ирээдүйн хөгжлийн явцад зах зээл баялгийн хуваарилалтад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх бөгөөд энэ нь тус гуравдугаар Бүгд Хурлаас гаргасан шийдвэрийн гол чиг шугам билээ. Эдгээр өөрчлөлтийн арга хэмжээ зугуухан хэрэгжиж эхлэснээр Хятад улс нь ирээдүйд улам тэнцвэртэй, уялдаатай, тогтвортой, тулхтай байдлаар хөгжих юм. Гуравдугаарт: Хятад улс нь ирээдүйд улам нээлтэй хэв маягаар хөгжих болно.

Хятадын ирээдүйн хөгжлийн чиг хандлага, ялангуяа өөрчлөлт шинэчлэлийн арга хэмжээ нь Монгол улс болон Хятад Монголын харилцааны хөгжилд ямархуу нөлөө боломжийг авчрах тухайд сая бид бүхэн маш тодорхой хэлэлцүүлгийг өрнүүлэв. Миний санахад та бүхний сая дэвшүүлсэн олон чухал санаа бодлуудыг бид нэн ултай бодож цэгнэх учиртай юм. Тухайлбал:

Хятад улс нь гадаадад хөрөнгө оруулах удирдлагын тогтолцоог өөрчилж, "хөрөнгө оруулалтыг хилийн дээсээр

алхан гаргах" стратегийг түргэсгэж байна. Бид гадаадад хөрөнгө оруулах тал дээр янз бүрийн хязгаарлалтыг багасгаж, зарим нэгэн урамшуулан дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд Хятадаас Монгол улсад оруулах хөрөнгө оруулалтын дүн нуруу, арга зам болон хэлбэрт гүн гүнзгий нөлөө үзүүлж, улам олон урсгал чиглэл рүү хувьсаж байгаа билээ.

Хятад улс нь чөлөөт худалдааны бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхдээ хил орчмын бүс нутгийг гол бааз сууриа болгож байгаа нь дэлхий нийтэд хандсан чөлөөт худалдааны бүсийн сүлжээг үүсгэхэд чиглэгдэж байна. Хятадын тал нөхцөл боломж бүрдсэн үед Монгол Улстай хоёр талын болон олон талыг хамарсан чөлөөт худалдааны зохицуулалтын асуудлыг хэлэлцэхийг хүсэж байгаа билээ. Миний бодлоор нөхцөл боломж аажимдаа бүрдэхийн сацуу хоёр талын бодитой хэлэлцээр цаг тухайдаа эхлэх нь дамжиггүй.

Хятад улс нь дотоод бүс нутгийг хил орчмын бүс нутаг руу нээлттэй болгох явдлыг өргөтгөснөөр гадаад ертөнцтэй харьцах эдийн засгийн коридорыг буй болгож эхлэв. Энэ нь "Улаанбаатар төмөр зам умард бүсийн түүхий эдийг тээвэрлэх төсөл" болон "Монголын өмнөд нутгийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд" бүр ч илүү өргөн орон зайг буй болгож байна.

Хятад улс нь хил орчмын бүс нутгуудыг нээлттэй болгох алхаагаа түргэсгэснээр хил орчмын томоохон боомт, хилийн хот, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүд хүн хүчний солилцоо, түүхий эд материалыг боловсруулах, аялал жуулчлал зэрэг тал дээр онцгой арга хэлбэр, бодлого хэрэгжүүлэх болов. Энэ бүхэн нь Эрээн хот-Замын үүд болон Ганц мод- Гашуун сухайтын хилийн боомтын эдийн засаг, хил дамнасан хамтын ажиллагаанд шинэ боломжийг олгож байгаа билээ.

Хятад улс одоо хотжуулах бүтээн байгуулалтыг түргэсгэж байгаа болохоор түүхий эдийн хэрэгцээ удаан хугацааны турш үлэмж өндөр түвшинд хадгалагдаж байх болно гэсэн үг юм. Энэ нь Хятад Монгол хоёр орны хоорондын түүхий эдийн ашиглалт, хэрэглээ болон худалдаанд улам илүү өргөн боломж олгож байгаа юм.

Хятад улс үнийг зах зээлийн механизмаар зохицуулах явдлыг улам бүр боловсронгуй болгож байна. Зах зээлийн зүгээс үнийг тогтоох шаардлагатай нөхцлийг олгосноор засгийн газрын зүгээс зөвхөн байх ёстой үүргээ гүйцэтгэж байх болно. Хятад улсын хөгжил цаашдаа улам илүү байгаль дэлхийдээ ээлтэй, тогтвортой чиглэлээр өрнөх бөгөөд энэ нь Хятад Монгол хоёр орон ирээдүйд нүүрс, газрын тос, цахилгаан эрчим хүчний салбарт хамтын ажиллагаа өрнүүлэхэд арга механизм, хөдөлгөх болон бүрэлдүүлэх хүчин зүйлсийн хувьд гүн гүнзгий нөлөө үзүүлэх төдийгүй улам өндөр шаардлага тавигдах нь тодорхой.

Товчоор хэлбэл хөрш зэргэлдээ чухал хамтын ажиллагааны түншүүд болохын хувьд Хятад Монгол хоёр орон түргэн хурдацтай хөгжих шатанд оршиж байна. Бид бүхэн тасралтгүй шинийг бүтээж, хамтран ажиллах боломжуудыг ашиглахын зэрэгцээ, хамтын ажиллагааны ухагдахуун, сэтгэлгээ ч өөрчлөлт шинэчлэлийн үзэл санааг эш болгон, цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхаж байвал зохино. Хятад Монголын харилцааг цаг үеийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй урагшлуулан хөгжүүлж байхын тулд хамтын ажиллагаагаа ч байнга уялдуулан зохицуулж байх шаардлагатай.

Хятад улс өөрчлөлт шинэчлэлийг гүнзгийрүүлж байна. Монгол Улсын шинэчлэлийн засгийн газар байгуулагдсан цагаасаа эхлэн өөрчлөлт шинэчлэлийн үйл хэрэгт ихээхэн хүчин чармайлт тавих болов. Саяхан ерөнхий сайд Н.Алтанхуяг Хятад улсад амжилттай айлчлах явцад хоёр тал стратегийн түншлэлийн хамтын ажиллагааны дунд, урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт гарын үсэг зурж, хоёр орны улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн салбарт олон төрлийн хамтын ажиллагаа өрнүүлэх тал дээр чухал ойлголцолд хүрэв. Хоёр талын төлөвлөж байгаа Хятад Монголын харилцааны хөгжлийн ирээдүйн чиг хандлагууд нь хоёр талын шинэ соргог зүйл, хувьсал өөрчлөлт, хөгжлийг эрэлхийлсэн сэтгэлгээний тусгал болсноор манай хоёр талын хөгжлийн төлөвлөгөө лүгээ яв цав нийцэж байна. Энэ нь Хятад Монголын харилцааг хөгжүүлэх явдал бол манай хоёр орны хөгжлийн дотоод хэрэгцээ шаардлагаас урган гарч байгаа болохоор хоёр талын язгуур эрх ашигт нийцэж байгааг тод томруун илтгэн харуулж

байна. Эдгээр ажил хэргийг гүйцэлдүүлэхийн тулд бид хүч хайрлалгүй зүтгэж, түүний үр шимийг дэлгэрүүлэн хоёр ард түмний сайн сайхны үйл хэрэгт зориулах ёстой.

Өнөөдрийн эрдэм шинжилгээний хурал нь Монголын талд Хятад улсын өөрчлөлт шинэчлэлийн үйл хэргийн гүнзгийрэлтийн талаар бүх талын гүнзгий ойлголт өгөхийн зэрэгцээ, хоёр талын харилцааг хөгжүүлэн хамтын ажиллагааг өрнүүлэх итгэлцлийг бэхжүүлж, харилцан ашигтай хамтран ажиллаж, хамтдаа хөгжин дэвжихэд нэгдмэл ойлголттой болох тал дээр хүчин чармайлтаа нэгтгэхэд тус дөхөм үзүүлж чадсан нь дамжиггүй. Хятадын талын хувьд бид өөрчлөлт шинэчлэлээ гүнзгийрүүлснээр Монгол Улсын хөгжил, Хятад Монголын харилцааны хөгжилд улам арвин их, илүү нааштай боломжуудыг олгох хүсэл эрмэлзэл дүүрэн байдаг. Хамтын хүчин чармайлтаар бид бүхэн олдсон боломжийг ашигласнаар Хятад Монголын харилцаа улам түргэн хурдацтай, улам сайн сайхнаар хөгжинө гэдэгт миний бие итгэлтэй байна.